

Батлав. Говьсүмбэр аймгийн байгаль орчны асуудал хариуцсан газрын дарга

\_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

УБ ТРАНС ХХК-ийн захирал Ж.БАТБАЯР

**ГОВЬСҮМБЭР АЙМАГ, СҮМБЭР СУМЫН НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ  
“УБ ТРАНС” ХХК -ЫН  
(ТӨСЛИЙН БАЙРШИЛ, НЭР)**

**2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2572923/


Хянасан: Говьсүмбэр аймгийн байгаль орчны асуудал хариуцсан газрын тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн \_\_\_\_\_

Биелэлтийг тайлагнасан:

УБ ТРАНС ХХК-ийн захирал Ж.БАТБАЯР



УБ ТРАНС ХХК-ийн Үйл ажиллагааны менежер Д.ҮҮРИЙНТУЯА



2022 он

Аялал жуулчлал, үйлчилгээний төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга

### **1. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ**

Байгаль орчин менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөнүүдийг бууруулах, багасгах, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь дараахи зорилгуудыг хэрэгжүүлэхэд оршино. Үүнд :

- ✓ Агаар, хөрсөн бүрхэвч, ургамал болон тухайн орчинд амьдарч, ажиллаж буй хүмүүст гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөнүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох
- ✓ Дээрхи арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичгийг тодорхойлох
- ✓ Шаардлагатай хөрөнгө зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох зэрэг орно.

### **2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

- ✓ Тоосжилтыг бууруулах зорилгоор хур тундас ороогүй үед хяналтын бүсд тоосжилт үүссэн үед худгийн усыг зориулалтын шүршигчээр шүршиж заншсан. /дулааны улиралд тогтмол хийж байгаа/
- ✓ Хаврын хуурайшилттай үед ил гар гарах, овоолготой нүүрс уугихааас сэргийлж 7 хоног бүр усны машинаар ус зөөврлөн шүршиж тоос буулгадаг.




- ✓ Төслийн талбайд том оврын автомашинууд болон техник хэрэгсэлүүдийг ажиллаагүй үед асаалттай орхихгүй байх талаар ажилчид болон үйллүүлэгчид байнга сануулга өгсөнөөр дадал болсон.

- ✓ Хар тугалганы агууламж багатай стандартын шаардлага хангасан чанартай түлш хэрэглэх, техникийн норм мөрдөж ажиллаж хэвшсэн.
- ✓ Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2015 стандартын дагуу Гаалийн хяналтын бүсэд байрлах гүнийн худгийн тоног төхөөрөмжийн эрүүл бүсийн арчилгаа хамгаалалтанд зориулж жил бүр 300.0 төгрөгийг төсөвлөн шаардлагатай арчилгаа хамгаалалтыг хийж гүйцэтгэсэн.
- ✓ Хөрс цөлжилтөөс хамгаалах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль, Ариун цэврийн тухай хууль MNS6260:2011 стандартын дагуу хөрсийг элдэв бохирдлоос хамгаалах, техник хэрэгсэлийн тос, масло асгарсан газрыг хатуу хучилттай болгох зорилготойгоор жил бүр боломжит хэмжээгээр хийж гүйцэтгэсээр байна.



- ✓ Ус ашиглалт хэрэглээг тоолууржуулах журам, Усны тухай хууль, Ундны ус эрүүл ахуйн шаардлага, түүнд тавигдах хяналт MNS 0900:2015 стандартын дагуу Гаалийн хяналтын бүсэд байрлах Унд-ахуйн худгийн ариун цэвэр болон аюулгүй байдлыг хангах зорилгоор худгийн хамгаалалтыг нийт 120,0 төгрөгний төсөвтэйгээр хийж гүйцэтгэсэн. Мөн тоолуурын заалтаар ус ашигласаны төлбөрийг цаг тухайд нь төлж байгаа.



- ✓ 2022 оны 2 дугаар сард “Эх Монголын Байгаль” ХХК-р №НВ/22-003 тоот гэрээ байгуулан Гаалийн хяналтын бүсэд “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа”-г хийлгэсэн. Төлбөр 2,200,000 төгрөг болсон байна.

### ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН ХЯНАН БАТАЛГААНЫ ДҮГНЭЛТ

Хянан баталгааны төрөл: Захиалгат хянан баталгаа **Огноо:** 2022-02-25

1. Газар ашиглагч: УБ транс
2. Аймаг (нийслэл): Говьсүмбэр **Сум (дүүрэг):** Сүмбэр
3. Байршил, хаяг: Говьсүмбэр, Сүмбэр, 1-р баг, Дэлгэрэх дэлгүүрийн хойд талд
4. Нэгж талбарын дугаар: 4201000498
5. Хөрсний нэр:
6. Ургамалжилт:
7. Нийт талбайн хэмжээ: 465 м<sup>2</sup>
8. Газар эзэмших зориулалт: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
9. Одоогийн газар ашиглалтын хэлбэр: Худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв, цогцолбор
10. Газар ашиглах, эзэмших шийдвэр: Говьсүмбэр аймаг /нийслэл/-ийн Сүмбэр сум/дүүргийн Засаг даргын 2004 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 04201-A/122/2004 тоот захирамж
11. Газар эзэмших эрхийн гэрчилгээний дугаар: 7963

#### 12. Эзэмшил газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

“УБ транс” ХХК -ийн Говьсүмбэр аймгийн сүмбэр сумын нутаг дэвсгэрт Засаг даргын 2012 оны 09-р сарын 19-ны өдрийн А/262 тоот тушаалаар Худалдаа, үйлчилгээний зориулалтаар 463м<sup>2</sup> талбайг 15 жилийн хугацаатай эзэмших эрх авсан байна.

Газрын төлөв байдал, чанарын тодорхойлолт

Газар ашиглалтын байдал	Талбай	Эвдэрч бохирдсон талбай		
		Физикийн	Химийн	Биологийн
Нийт эзэмшил газар	466	+	-	-
Нэгж талбарын талбай	466	+	-	-
Газар дээрээ ашиглаж байгаа талбай	438	+	-	-
Дутуу ашиглаж байгаа газар	144	+	-	-

### 3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт

- ✓ Төслийн нутаг дэвсгэр дэх ургамлан бүрхэцийн талхагдалд орсон талбайг нэмэгдүүлэхгүй байх зорилгоор Гаалийн хяналтын бүсийн задгай талбайд мод, сөөг, олон наст болон нэг наст ургамал тарьж ургуулах ажлын хүрээнд талбайн арын хэсгээр чацарганы мод, оффисын эргэн тойронд цэцэг болон мод тарьсан.
- ✓ Эдгээр ажлууд нь БОМТ-нд жил бүр заагдсан байдаг тул бид жил бүр тогтмол хийж гүйцэтгэдэг болно.





#### **4. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт**

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон архелогийн ба палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй. Цаашид үйл ажиллагааны явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн 1-р бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтанд байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судлаж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчилах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах болно. Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь төслийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. БСШУ-ны яамны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон байдаг. Бид мөн үүргээ биелүүлэн хариуцлагаа ухамсарлан ажиллаж байгаа болно.

#### **5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт**

- ✓ Гаалийн хяналтын бүс дотор болон ойролцоох гадна хэсгийн туурь хог, нүх шуудууг түрж тэгшлэх ажлыг улиралд 1 удаа 100.000 төгрөг ба нийт 400.000 төгрөгний төсөвтэйгээр цэвэрлэж заншаад байна. Мөн бид нийгмийн хариуцлагын хүрээнд өөрийн Гаалийн хяналтын бүсийн ойр орчим хаягдсан шороо болон жоншны хог хягдалыг өөрийн эзэмшилийн машин техникээр, нийт ажилчдын хамтаар 3 гаруй сая төгрөгийн түлш шатахуун зарцуулан жил бүр цэвэрлэж байгаа юм.
- ✓ Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж байгаа Гаалийн хяналтын бүсүүдэд ЗТХЯ болон УБТЗ ХНН-ээс салбар замыг нэг удаагийн тавилтаар 50 вагон ачих хэмжээнд өргөтгөж хүчин чадлыг нэмэгдүүлэх үүрэг өгөгдсөн. Тухайн үүргийн хүрээнд манай компани нь хяналтын бүсийн газрыг өргөтгөж, хуучин ашиглаж байсан 2 төмөр замыг тус бүр 125 метрээр уртасгаж барьсан. Ингэхдээ хяналтын бүсийн баруун талын газрыг сунган, сунгасан газрын туйр хог хаягдлыг цэвэрлэж, тухайн хэсгийн газрыг автогридер болон индүүгээр тэгшилсэн. Үүнд нийт 3,000,0 төгрөгний төсөв зарцуулсан.





- ✓ Гаалийн хяналтын бүсэд байсан гадаах бие засах газар нь хөрсний бохирдол үүсгэх сөрөг нөлөөтэй байсан тул хөрсийг халдваргүйжүүлэн шороогоор дүүргэн дээр нь хог хягдлыг ангилан ялгах хогийн сав байршуулсан болно. Тиймээс ажилчдын ажлын байр буюу оффист боловсон бие засах өрөөг хийж тохижуулан бохирыг соруулдаг болж хэвшсэн юм. Төлбөрийг цаг тухайд нь төлж байна.
- ✓ Ажилчдын ажлын байранд 5 ширхэг ангилах хогийн савыг нийт 50.000 төгрөгөөр авч тавьсан ба жил бүр шинэчилдэг.
- ✓ Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хуульд зааснаар галын аюулгүй байдлын шинэ нөөц санг нийт 5,046,900 төгрөгний төсөвтэйгээр авч бүрдүүлсэн.

### **6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт**

Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо, Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо, Ундны усны бүрэн шинжилгээ, Ундны усан дахь хүнд металлын агууламж зэрэг шинжилгээнүүдийг Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвд өгчнийт 530,600 төгрөгийн төсөвтэйгээр шинжлүүлсэн. / Шинжилгээний дүгнэлт болон шинэжилгээ авч буй зураг хавсаргав./







# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2022 онд 11 сарын 21 өдөр

Дугаар 38

Чотр

Дугаар, он /№ :  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : UBTRANS ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : М.Мөнхтүвшин /Лабораторийн техникч/  
 Дээжийн төрөл, тоо : Хөрс агрохими  
 Сорьц авсан огноо : 2022.11.14  
 Дээжийн хэмжээ /гр/ : 200 гр  
 Дээжийн тодорхойлолт : Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум  
 Шинжилсэн огноо : 2022.11.14 – 2022.11.21  
 Хуудасны тоо : 2

Д/д	Агрохимийн үзүүлэлтүүд	Нэгж	Цэг	Шинжилгээний дүн
1	Анхан шатны боловсруулалт	№	Гүний худгийн хажуу тал	0,25 мм-ийн хуурай шигшүүрийн арга
			Ачилтын хэсэг	
			Ажлын байрны хажуу тал	
			Эрүүл хөрс	
2	Сульфат /SO <sub>4</sub> / тодорхойлох	Mг/кг	Гүний худгийн хажуу тал	40.3
			Ачилтын хэсэг	43.5
			Ажлын байрны хажуу тал	45.0
			Эрүүл хөрс	39.0
3	Фосфор /P <sub>2</sub> O <sub>5</sub> / тодорхойлох	Mг/кг	Гүний худгийн хажуу тал	25.3
			Ачилтын хэсэг	24.7
			Ажлын байрны хажуу тал	23.6
			Эрүүл хөрс	23.0
4	Нитрат /NO <sub>3</sub> / тодорхойлох	Mг/кг	Гүний худгийн хажуу тал	9.79
			Ачилтын хэсэг	8.28
			Ажлын байрны хажуу тал	9.15
			Эрүүл хөрс	7.25
5	Ялзмаг тодорхойлох	Mг/кг	Гүний худгийн хажуу тал	0.92



			Ачилтын хэсэг	0.94
			Ажлын байрны хажуу тал	0.96
			Эрүүл хөрс	0.88
6	Аммоний /NH <sub>4</sub> / тодорхойлох	Огноо	Гүний худгийн хажуу тал	42.0
			Ачилтын хэсэг	21.3
			Ажлын байрны хажуу тал	29.6
			Эрүүл хөрс	25.0
7	РН-метр тодорхойлох	Огноо	Гүний худгийн хажуу тал	21.9
			Ачилтын хэсэг	8.80
			Ажлын байрны хажуу тал	8.89
			Эрүүл хөрс	8.78
8	Чийг тодорхойлох	%	Гүний худгийн хажуу тал	1.03
			Ачилтын хэсэг	1.05
			Ажлын байрны хажуу тал	1.02
			Эрүүл хөрс	1.02

Шинжилгээ боловсруулсан: Техникч *Мөнхтүвшин* / М.Мөнхтүвшин /

Хянасан: УЦУОШТөвийн дарга *[Signature]* / Э. Энх-Од /

Энэхүү шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуулбарлахыг хориглоно.



# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 39

Мөвөр

Дугаар, он /№ : 14/11/2022  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : " UBTRANS " ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : М.Мөнхтүвшин / Лабораторийн техникч /  
 Дээжийн төрөл, тоо : Ус  
 Сорьц авсан огноо : 2022.11.14  
 Дээжийн хэмжээ : 1 литр  
 Дээжийн тодорхойлолт : Усны сорьц  
 Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999  
 MNS 62715:2011 MNS 4424:2005  
 Шинжилсэн огноо : 2022.11.14 – 2022.11.21  
 Хуудасны тоо : 1/1  
 Үр дүн : 1

Сорьцын нэр	PH	ES	SO <sub>4</sub> мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO <sub>3</sub> мг/л	Эрд мг/л	Хат мг/эк в/л
Худгийн ус	7.83	1083	301.8	57.8	79.0	43.7	172.0	396.6	1050.9	7.53

Шинжилгээ боловсруулсан: Техникч *М.Мөнхтүвшин* / М.Мөнхтүвшин /

Хянасан: УЦУОШТөвийн дарга *[Signature]* / С. Энх-Од /



# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2022 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 40

11-09

Дугаар, он /№ : 14/11/2022  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : " UBTRANS" ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал : М.Мөнхтүвшин Лабораторийн техникч  
 Дээжийн төрөл, тоо : Ус  
 Сорьц авсан огноо : 2022.11.14  
 Дээжийн хэмжээ : Летр  
 Дээжийн тодорхойлолт : Усны сорьц  
 Шинжилгээний аргын стандарт : MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999  
 MNS 62715:2011 MNS 4424:2005  
 Шинжилсэн огноо : 2022.11.14 – 2022.11.21  
 Хуудасны тоо : 1  
 Үр дүн : 1

Сорьцын нэр	Ж/б	ПИЧ	NH <sub>4</sub> мг/л	NO <sub>2</sub> мг/л	NO <sub>3</sub> мг/л	Р <sub>эрд</sub> мг/л	F мг/л
Худгийн ус	4.0	0.8	0.05	0.099	0.32	0.002	0.64

Шинжилгээ боловсруулсан: Техникч  М.Мөнхтүвшин /

Хянасан: УЦУОШТөвийн дарга  / З. Энх-Од /

Энэхүү шинжилгээний дүн нь зөвхөн шинжилгээ хийсэн дээжинд хамаарна. Шинжилгээний дүнг лабораторийн зөвшөөрөлгүй хуульарлахыг хориглоно.



# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2022 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 57

Чойр

Дугаар, он / №

Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас:	"UBTRANS" ХХК
Дээжийг авсан хүний нэр, албан тушаал:	М.Мөнхтүвшин /Лабораторын техникч/
Дээжийн төрөл, тоо:	Тоосны бохирдол
Сорьц авсан огноо:	2022.11.14
Дээжийн хэмжээ/ мг/м <sup>3</sup> :	24 Цаг PM10-PM2.5
Дээжийн тодорхойлолт:	Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум
Шинжилсэн огноо:	2022.11.14-2022.11.15
Хуудасны тоо:	1

Цаг	24 цаг	Ажилчдын байр		Ачилтын хэсэг	
		PM 2.5 мкг/м <sup>3</sup>	PM 10 мкг/м <sup>3</sup>	PM 2.5 мкг/м <sup>3</sup>	PM 10 мкг/м <sup>3</sup>
Хүлцэх агууламж /стандарт/		50	100	50	100
24 цаг		92.5	34.7	83.3	30.9

Шинжилгээ боловсруулсан: Техникч

Хянаж баталгаажуулсан: УЦУОШТөвийн дарга

/ М.Мөнхтүвшин /

ГЭЭНХ-ОД /



# ГОВЬСҮМБЭР УЦУОШТ

БАЙГАЛЬ ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ЛАБОРАТОРИ

ЛАБОРАТОРИЙН СОРИЛТЫН ДҮН

2022 оны 11 сарын 21 өдөр

Дугаар 41

Чайр

Дугаар, он/№  
 Дээжийг ирүүлсэн газрын нэр, хаяг, утас: "UBTRANS" ХХК  
 Дээжийг авсан хүний нэр, албан тушаал: М.Мөнхтүвшин /Лабораторийн техникч/  
 Дээжийн төрөл, тоо: Хөрс  
 Сорьц авсан огноо: 2022.11.14  
 Дээжийн хэмжээ /гр/: 200 гр  
 Дээжийн тодорхойлолт: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум  
 Шинжилсэн огноо: 2022.11.14-2022.11.21  
 Хуудасны тоо: 1

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Кобальт (Co)	Стронци (Sr)
1	Гүний худгийн хажуу тал	илр	21.4	0.1	илр	92.5	24.8	13.0	290.1
2	Ачилтын хэсэг	илр	306.2	илр	илр	290.7	0.0	53.9	375.8
3	Ажлын байрны хажуу тал	илр	100.4	илр	илр	74.2	26.1	21.2	337.0
4	Эрүүл хөрс	илр	27.4	илр	илр	55.4	21.6	5.7	330.6
5	MNS 5850 2009 (ЗДХ)	3	100	2	150	300	100	50	800

Шинжилгээ гүйцэтгэсэн: Техникч

/ М.Мөнхтүвшин /

Хянаж баталгаажуулсан: УЦУОШТ-ийн дарга

/ Э.Энх-Од /



### **7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт**

Жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хийж батлуулан тухайн төлөвлөгөнд тусгагдсан ажлуудыг Үйл ажиллагаа хариуцсан менежер болон Гаалийн хяналтын бүсийн эрхлэгч нар хамтран шат дараатай хийж гүйцэтгэдэг.

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний хүрээнд мод тарих ажлыг 2022 оны 8 дугаар сарын 6,7,27,28-ний өдрүүдэд компанийн нийт ажилчид 2 ээлж болон хуваагдан хийж гүйцэтгэсэн байгаа. Үүнд нийт 3,500,000 төгрөг зарцуулсан болно.

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний хүрээн дэх ажлуудыг 2022 оны 3 дугаар сараас эхлэн шат дараалалтайгаар хийж гүйцэтгэсэн байна.

Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээн дэх ажлуудыг заасан тухайн хугацаа буюу улирал тутамд хийж гүйцэтгэсэн.

Дээрх ажлын хүрээнд нийт 13,225,000 төгрөг төсөвлөсөн байсан боловч 18,146,900 төгрөг болон нэмэгдэж Үйл ажиллагааны менежерийн хяналтан доор уг төсвийг бүрэн зарцуулж дуусгасан болно.

Мөн 2022 он дуусахаас өмнө “Байгаль орчны аудит” болон шинээр нэмэгдсэн талбайн “Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан” зэргийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр гэрээ хийсэн байгаа.

### **8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт**

Хяналтын бүсийн ажилчид, захиргаа алба, хяналтын бүсийн үйлчлүүлэгч нар, оршин суугч нарыг байлцуулан компанийн БОМТ-г танилцуулан, түүнтэй холбоотой хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаануудыг тайлагнах зөвөлгөөнийг 2022 оны 12 дугаар сарын боломжит өдөр хийхээр төлөвлөсөн байгаа.

Анхаарал тавьсанд баярлалаа.